



СЕКЮРИТИЗ  
ҮЦК

2022.05.23-2022.05.27

# ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



2022.05.30-ны after trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
US30	33,257.00	0.14%	4.31%	0.58%	-3.82%
US500	4,172.71	0.34%	4.99%	0.40%	-0.72%
NASDAQ	12,757.00	0.60%	6.01%	-2.44%	-6.57%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
GB100	7,585.00	0.27%	2.65%	1.02%	8.01%
DE40	14,462.00	1.62%	3.44%	3.45%	-6.82%
FR40	6,516.00	1.64%	3.67%	0.12%	0.49%
IT40	24,636.00	0.37%	2.25%	2.41%	-2.12%
ES35	8,934.00	0.50%	5.29%	4.95%	-3.15%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
JP225	27,260.00	1.79%	0.88%	1.57%	-5.61%
SHANGHAI	3,129.00	-0.03%	-0.56%	2.01%	-13.44%
CSI 300	3,999.00	-0.05%	-1.35%	-0.27%	-24.99%
SHANGHAI 50	2,762.00	-0.04%	-0.74%	-1.39%	-24.33%
CH50	13,261.36	0.70%	-1.97%	-0.78%	-27.54%
SENSEX	54,885.00	1.17%	1.03%	-4.58%	6.73%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Газрын тос (Crude Oil)	115.55	0.43%	4.76%	11.72%	72.63%
Газрын тос (Brent)	119.59	0.13%	5.48%	11.21%	72.59%
Байгалийн хий	8.84	1.34%	1.14%	18.31%	189.68%
Шатахуун	4.02	0.22%	5.98%	14.66%	87.52%
Нүүрс	406.65	0.91%	-2.54%	24.72%	283.63%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Алт	1,852.64	-0.01%	-0.12%	-0.64%	-2.91%
Мөнгө	22.04	-0.26%	1.06%	-2.78%	-21.57%
Зэс	4.31	0.39%	-0.79%	1.10%	-7.85%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
АНУ	2.74	0.0288	-0.07%	0.00%	1.21%
Англи	1.93	-0.0430	0.03%	0.05%	1.13%
Швейцар	0.75	0.0290	0.03%	-0.10%	0.95%
Испани	2.06	-0.0010	-0.02%	0.15%	1.58%
Португали	2.10	0.0170	-0.09%	0.03%	1.64%

Эх сурвалж: Trading economics



## АНУ-ын хөрөнгийн зах зээл сэргэж эхлэв үү?

Хөрөнгийн зах зээл сүүлийн 49 хоног дараалан унасан нь 2001 оноос хойших хамгийн урт хугацааны уналт байсан ч өнгөрсөн 7 хоногт хүчтэй сэргэлт үзүүллээ. Компаниудын санхүүгийн үзүүлэлт сайн байгаагаас гадна Холбооны Нөөцийн Сан уян хатан бодлого баримтлах талаар бага зэргийн найдвар өгснөөр S&P 500 индекс сүүлийн нэг жилийн доод ханшаасаа өсөж эхэллээ.

### Өнгөрсөн 7 хоногт шинжээчдийн олж мэдсэн 3 зүйлсийг дурдвал:

#### 1. Өрхийн худалдан авалт

**Олны таамаглал:** Инфляцын түвшин өндөр байгаа үед өрхийн худалдан авалт буурна.

**Олны таамгаас сөрөх үндэслэл:** Хэдий макро эдийн засгийн мэдээ тааруу байгаа ч өрхийн худалдан авалтын эрэлт тогтвортой байна. Зарим худалдааны бизнесүүдийн санхүүгийн тайлан таамгаас доогуур гүйцэтгэлтэй гарсны гол шалтгаан нь худалдан авалтын эрэлт бууснаас бус зардал өссөнтэй холбоотой байсан.

Өнгөрсөн 4 сард өрхийн худалдан авалт сүүлийн 3 сар дундаас хамгийн хурдтай өссөн сар байсан нь ажлын байрны тоо нэмэгдэх болон өрхийн хадгаламж өссөнөөс улбаатай байв. Walmart, Target өөрсдийн борлуулалтын төсөөллөө бууруулсан ч Macy's, Nordstrom, Ralph Lauren компаниуд борлуулалтын төсөөллөө өсгөсөн нь эдийн засгийн нөхцөл байдал муугаар төсөөлж байснаас илүү сайн байж магадгүйг харуулсан. Худалдааны бизнесүүдийн хувьд борлуулалт болон эрэлт хангалттай өсөж байгаа ч цалин, тээврийн зардал өсөж байгаагаар холбоотойгоор цэвэр ашгийн хэмжээ буурч байна.

АНУ-ын бодит өрхийн худалдан авалт  
/тэрбум доллар/



Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)


## 2. ХНС-ийн мөнгөний бодлого

**Олны таамаглал:** ХНС АНУ-ыг эдийн засаг хямралд ортол бодлогын хүүг өсгөнө.

**Олны таамгаас сөрөх үндэслэл:** ХНСанг 6, 7 сард бодлогын хүүг их хэмжээгээр өсгөх вий гэсэн олны болгоомжлол намдаж, төв банкны илүү уян хатан хандана гэсэн хүлээлт үүссэн.

Хөрөнгө оруулагчдын зүгээс хамгийн их болгоомжилж байсан зүйл нь ХНС бодлогын хүүг хэт ихээр өсгөснөөр эдийн засгийн хямралыг эхлүүлнэ гэж бодож байсан. 5 сард ХНС-аас өгсөн мэдээллээр төв банкны зүгээс эхний ээлжид бодлогын хүүг хүчтэй өсгөөд, дараагийн ээлжид илүү уян хатан байх боломжтой талаар мэдэгдсэн. Ихэнх шинжээчид энэхүү мэдээг ХНС бодлогын хүүг 0.5%-иар шат дараалалтай өсгөнө гэж хүлээж авсан. ХНС-ийн мөнгөний бодлого хөрөнгө оруулагчдын ойрын үед гол анхаарлаа хандуулах мэдээ байх ба инфляцаас хамаарч хэр их өсөх нь тодорхой болно. Бодлогын хүүг хэт их өсгөхөөс бусдаар эдийн засгийн өсөлт хэвийн байх төлөвтэй байна.

Шинжээчдийн таамагласан АНУ-ын бодлогын хүүгийн төсөөлөл



Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)

## 3. Инфляц

**Олны таамаглал:** Инфляцын түвшин өндөр хэвээр байх болно.

**Олны таамгаас сөрөх үндэслэл:** Инфляцын түвшин 4 сард өмнөх сараас буурсан үзүүлэлттэй гарсан нь цаашид буурах хандлагатай байж магадгүйг харуулж байна.

40 жилд тохиогоогүй дээд инфляцын түвшин төв банкны хатуу мөнгөний бодлого баримтлахад хүргэсэн. Инфляц хэдий дээд түвшнээсээ бууж байгаа дүр зурагтай байгаа ч төв банкны зорилтот түвшин болох 2%-д хүрэхэд тодорхой хугацаа орох нь ойлгомжтой боллоо. Бондын зах зээлээс тооцсон 5 болон 10 жилийн хугацаатай инфляцын түвшний таамаглалууд буурч байгааг доорх зураг харуулж байна. Орон сууцны зээлийн хүү өсөж байгаа нь байрны худалдан авалтыг бууруулж, хэрэглээний эрэлт саарч, нийлүүлэлт хэвийн байдалд орсноор инфляцыг бууруулах боломжтой юм.

5 болон 10 жилийн дараах инфляцын таамаглал



Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)


## Дэлхий дахинд цар тахал дуусаагүй байхад Moderna-ийн хувьцаа яагаад унав?

Ковид-19-ийн вакцин үйлдвэрлэгчдийн нэг Moderna-ийн хувьцаа 2021 оны 8 сарын оргил цэгээсээ одоогийн байдлаар 75% унасан байна. Энэхүү уналт нь цар тахал дуусаагүй байгаа өнөөгийн нөхцөлд ойлгомжгүй харагдаж байж болох юм. АНУ болон БНХАУ-д Ковид-19 шинээр тусаж байгаа хүмүүсийн тоо рекорд эвдэхээр өсөж байгаа ба Moderna компанийн зүгээс энэ жил 20 тэрбум долларын борлуулалт хийх төлөвлөгөөтэй байгаагаа зарласан.

Хэрвээ дээрх суурь үзүүлэлтүүд тийм эерэг байгаа юм бол хувьцааны ханш яагаад унаад байгаа талаар бодогдуулж байна. Гол шалтгаан нь хөрөнгө оруулагчид ирээдүйг харж аливаа хувьцааг авдагт байгаа юм. Moderna-ийн ханш 2020 оны 3 сараас 2021 оны 8 сарын хооронд 477% өсөж байсан. Энэ нь хөрөнгө оруулагчид тухайн үеийн компанийн үнэлгээнд бус ирээдүйн үнэ цэнийг нь үнэлж авч байсан гэсэн үг юм.

Харин одоо Moderna-ийн өнөөгийн үнэ цэнийг тооцоход хувьцааны ханшаас доогуур байгаа тул зарж байгаа нь хувьцааны ханш унахад нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл 2020 онд олны таамаглашгүй мэдээн дээр тулгуурлаж хувьцааны ханш өссөн бол одоо бодит ханшин дээрээ бууж байна гэсэн үг.

[MRNA] Moderna-ийн ханш



Эх сурвалж: Investing.com

